

МОНГОЛ УЛС ДАХЬ МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА, АНХААРАХ АСУУДАЛ

Э.Одбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8011 дүгээр дамжааны суралцагч, цагдаагийн хошууч

Хураангуй: Энэхүү нийтлэлээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн олон улсын болон Монгол Улс дахь нөхцөл байдал, энэ төрлийн гэмт явдалтай тэмцэх үйл ажиллагааны үр дүн, тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар өөрийн санал дэвшүүлэн гаргахыг зорилоо.

Түлхүүр үгс: Гэмт хэрэгтэй тэмцэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, хууль бус эргэлт.

Abstract. In this article, I intend to put forward my suggestions about the situation of illegal trafficking of narcotic drugs and psychoactive substances internationally and in Mongolia, the results of activities to combat this type of crime, the problems, and the measures to be implemented in the future.

Key words. Crime fighting, narcotics, psychotropic substances, illegal trafficking.

Оршил. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-ны 2022 оны тайланд мансууруулах бодисын тариалалт, үйлдвэрлэлт, эрэлт нийлүүлэлт огцом өсөж, гэмт бүлэглэлүүдийн үйл амжиллагаа, цар хүрээ өргөжиж, мансууруулах бодисыг тээвэрлэх, түгээх шинэ арга хэлбэрийг ашиглаж байгаа талаар дурьдсан байна. Түүнчлэн мансууруулах үйлчилгээ үзүүлдэг ургамал болон эмийн хэрэглээ дэлхий нийтээр өссөн байна⁸⁵.

Дээрх нөхцөл байдлын өөрчлөлттэй уялдуулан

мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх гадаад хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлэх, шинэ мэдээллийг шуурхай харилцан солилцох зайлшгүй шаардлага тулгарч байна. Иймд Монгол улс дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн өнөөгийн нөхцөл байдлыг анхаарах зайлшгүй шаардлага үүсч байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар ашиглах гэмт хэргийн түүхэн уламжлал. Судлаачдын үзэж байгаагаар хүн төрөлхтөн

⁸⁵ НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-ны 2022 оны тайлан. Цахим эх сурвалж:

<https://www.unodc.org/unodc/en/data-and-analysis/wdr2021.html>

мансууруулах бодисыг эртнээс таньж, хамгийн анх намуу цэцгийг Месопатамчууд⁸⁶ манай тооллын өмнөх 340 жилийн тэртээ хэрэглэж байсан нь эртний булш, бунханаас олдсон эд өлгийн зүйл, хадны сүг зураг зэргээс ажиглагддаг⁸⁷ тухай тэмдэглэсэн байна. 1839-1842, 1858 онд Манж Чин улс, Англи улстай хийсэн “хар тамхины I, II дайн”-д ялагдсанаар дайны төлбөрт нийт 25 сая доллар төлөх болжээ. Иймд торго, цай зэрэг дотоодын бүтээгдэхүүнээ гадаадад гаргаж оронд нь хар тамхи оруулж, хэрэглэх явдлыг өөрийн эзэмшлийн орнуудад чөлөөтэй болгожээ. Тухайн үед зөвхөн Хятадад хар тамхийг 1 сая хүн хэрэглэдэг байсан бол XX зууны эхэн үе гэхэд хэрэглэгчийн тоо даруй 100 саяд хүрсэн байна. Энэ байдал нь Манжийн колони байсан Монгол оронд шууд нөлөөлж Манжийн төрийн бодлогын оролцоотойгоор эхэлсэн ба Монголд цагаачлан ирсэн хятад иргэд Манжийн хятадчилалдсан төрөөс явуулсан Шинэ засгийн бодлогоор хятад иргэдийг Ар монголд суурьшуулах шийдвэр гаргаж байсан нь байдлыг улам дэвэргэж, ядуу буурай монголын нийгэмд бодитой аюул занал учруулж эхэлсэн байна⁸⁸.

Манай улсын хувьд хар тамхины төрлийн ургамал “опиум, намуу цэцэг, зэрлэг олс г.м” ургадаг боловч нийгмийн хөгжлийн онцлог, ард түмний сэтгэхүйтэй холбоотой тэдгээрийг хэрэглэж заншаагүй цөөн тооны улс орны нэг юм⁸⁹.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг нэр томъёоны хувьд авч үзвэл, хууль зүйн талаас мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис гэдэгт – “донтуулах болон сэтгэцэд бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, Мансууруулах эмийн тухай 1961 оны НҮБ-ын конвенц, Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай 1971 оны НҮБ-ын конвенцийн жагсаалтанд заасан, хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад хяналтад байлгавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэлийг хэлнэ⁹⁰” гэж тодорхойлсон байдаг.

Зарим сурах бичгүүдэд мансууруулах бодис буюу хар тамхи гэдгийг төв мэдрэлийг тодорхой дарааллаар дарангуйлж нийтэд нь юмуу нэгээхэн хэсэгт нь мэдээ алдуулагч бодисууд гэж бүтцийнх нь талаас тодорхойлдог.

Харин Я.Цэвэлийн монгол хэлний толь тайлбар толь бичигт “намуу цэцгийн төрөл урт бөгөөд том навчтай, шар буюу улаан

⁸⁶ Азийн баруун урд хэсэгт оршиж байсан омог.

⁸⁷ ХЗЯ, УМБГ. Хар тамхитай холбоотой гэмт хэргийг шалгахад анхаарах зарим асуудал. – УБ., 2014. 5 дахь тал.

⁸⁸ Ж.Болдбаатар. Хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар борлуулах гэмт

хэргийн эрүүгийн эрх зүйн болон криминологи шинж. – УБ, 2000. 12 дах тал.

⁸⁹ Д.Адъяабазар. Мафи /Гэмт байгууллага/. – УБ, 1999. 84 дэх тал

⁹⁰ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай нийтлэл. – УБ. 2002. №46.

цэцэгтэй ургамал, түүнийг гүйцэд боловсроогүй байхад огтолж сүү мэт шүүсийг авч хатаасныг хэлнэ” гэж гаднах шинж чанарыг заасан⁹¹ бол англи хэлний толь бичигт “грек үгнээс гаралтай бөгөөд хөшөөх, мэдээ алдуулах, мансууруулах чанартай тодорхой зүйлийн ургамлын гаралтай химийн бодис, хортойгоор хэрэглэвэл хар тамхинд донтох өвчин үүсгэнэ¹⁴” гэж үзэн энэ бодисыг эмнэлэг анагаах ухаанд мэдээ алдуулах, өвчин намдаах, нойрсуулах зорилгоор хэрэглэгдэж болох тухай тайлбарласан байна. Бидний бодлоор мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодис гэдэг нь эмийн найрлагад агуулсан эсхүл байгалийн болоод нийлэгжүүлэх аргаар гаргаж авсан мансууруулах үйлчилгээ үзүүлж, хүний бие, оюун ухааныг түр зуур идэвхжүүлэх боловч түүнийг хэрэглэснээр төв мэдрэлийн системд нөлөөлж, сэтгэцийн хүнд өвчнөөр өвчлүүлэх, донтуулах үйлчилгээтэй бодис тэдгээрийн нэгдэлийг хэлнэ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн шинж. Объектын хувьд хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих талаар хуулиар тогтоосон журам байна.

Халдлагын зүйл нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, мансууруулах бодисын түүхий эд байна.

Объектив тал. Хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн идэвхтэй үйлдэл байна⁹². Эдгээр үйлдлийн аль нэгийг хийснээр төгсдөг хор уршиг учирсан байхыг шаардахгүй, хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм.

Субъектив тал. Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгднэ. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах нь хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байдаг.

Субъект. 14 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хэн ч байж болно. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг нь Эрүүгийн хуульд зайлшгүй байвал зохих нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй, хор уршиг учруулдаг үйлдэл, эс үйлдэхүй байх шинжээрээ гэмт хэргийн шинжийг агуулж байгаа юм.

Олон улсын болон Монгол Улсын нөхцөл байдал. Мансууруулах бодисыг тээвэрлэхдээ шуудан илгээмжийг


⁹¹ Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь. – УБ. 1966. 456 дах тал.

⁹² С.Гантулга, Б.Энхболд. Монгол Улсын эрүүгийн эрх зүй /тусгай анги/. – УБ. 2018. 313 дах тал.

ихэвчлэн ашиглаж, захиалга болон худалдаа цахим орчинд (darknet буюу цахим орчин дахь хар зах зээл) бүрэн шилжин цар тахлын хязгаарлалтанд хамаарахгүй түгээлтүүдийн /дрон ашиглах, хүнсний болон эм эмнэлэгийн хэрэгслийн хүргэлт, түгээлт гэх мэт/ хэлбэрүүдийг өргөн ашиглах болсон нь онцгой анхаарал татах болж

байна⁹³. Тухайлбал, Афганистан Улсад үйлдвэрлэгдсэн метафетамин хямд үнээр их хэмжээтэй хар зах зээлд нийлүүлэгдэж Арабын Нэгдсэн Эмират, Кувейт, Шри Ланка, Мальдив, Австрали, Индонези болон Балканы орнууд руу чиглэсэн гэмт бүлэглэлийн шинэ маршрут бий болсон байна⁹⁴.

Зураг 1. Афганистанд үйлдвэрлэсэн мансууруулах бодисын хууль бус эргэлтийн чиглэл, маршрут⁹⁵



Манай улсын хувьд сүүлийн 4 жилийн байдлаар улсын хэмжээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой 870 гэмт хэрэгт 1200 хүн холбогдон шалгагдаж 2022 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой 115 хүнд холбогдох, 69 гэмт хэрэг, үйлдлийг илрүүлж, эд мөрийн баримтаар 352.81 грамм метамфетамин (мөс), 31 кг 175

грамм каннабис (олсны ургамал), 24.5 грамм каннабисын тоос, 67.6 грамм “гашиш”, 17 ширхэг (тебантин), 392.8 грамм DXM (декстрометорфан), 2 литр 651 грамм синтетик (Дроп), 26.7 грамм псилоцин (шидэт мөөг), 18 ширхэг трамадол, 1 ширхэг комикс, 12 ширхэг морфин зэрэг бодисуудыг тус тус хураан авч байна.


⁹³ НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-ны 2021 оны тайлан

⁹⁴ “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт” сэдэвт

Интерполын 3 дахь удаагийн олон улсын бага хурлын тэмдэглэл. 2021.

⁹⁵ Мөн тэнд.

Хүснэгт 1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн судалгаа



Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийг улсын хэмжээнд бүртгэгдсэн жилийн эцсийн сарын байдлаар авч үзвэл 2017 оны 12 сард 90, 2018 оны 11 сард 190, 2019 оны 12 сард 257, 2020 оны 12 сард 202, 2021 оны 08 сард 107 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн байна⁹⁶.

“Ковид-19” цар тахлын улмаас тогтоосон хөл хорио, хязгаарлалтаас хамаарч гаднаас нийлүүлэгдэх мансууруулах бодис хомсдсоноор тархалт ихтэй аймаг, сумдын нутаг дэвсгэрээс каннабисыг түүж бэлтгэн боловсруулж хэрэглэх, мансууруулах үйлчилгээтэй эм, эмийн түүхий эд бэлдмэлийг зориулалтын бусаар ашиглах, энэ төрлийн эм хэрэглэдэг өвчтөнүүдийн жорыг ашиглах,

хуурамч жор үйлдэн олж авч хэрэглэх явдал нэмэгдсэн.

Газарзүйн байршил, бүс нутгийн онцлогоос хамааран Афганистанд үйлдвэрлэсэн үнэ хямд мансууруулах бодис (метафетамин) Монгол Улсад нийлүүлэгдэх магадлалтай байгаа нь зайлшгүй анхаарах асуудлын нэг болж байна.

Хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ. Монгол Улс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх түүхэн уламжлалтай бөгөөд тухайлбал Богд Хаан 1912 оны 06 сарын 27-нд хар тамхийг тээвэрлэх, худалдах, хэрэглэхийг цаазлан хорих тухай зарлиг гаргаж байжээ.

Манай улс Нэгдсэн үндэстний байгууллагаас гаргасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт

⁹⁶ Цахим эх сурвалж холбоос.
https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2300_036V4

бодисын эсрэг конвенциудад нэгдэн орж, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Казахстан Улстай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийг байгуулан хамтран ажиллаж байна.

Монгол Улсын төр мансууруулах бодисын талаарх олон улсын санал, санаачилга болон үүрэг зорилтыг хангахын төлөө хүчин чармайлт гарган ирсэн бөгөөд 2002 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хуулийг баталж, 2000-2005 онд “Хар тамхи, мансуурахтай тэмцэх үндэсний хөтөлбөр” хэрэгжүүлсэний үр дүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн илрүүлэлт өсч гаралт буурсан.

Монгол Улсын Засгийн газраас 2017 онд 4 жилийн хугацаатай хэрэгжүүлэх “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байгаа ба мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгаас урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, иргэдийг соён гэгээрүүлэх гол зорилгыг агуулсан байдаг.

Нэгдсэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас мансууруулах бодис хууль бусаар улсын хилээр нэвтрүүлсэн, бусдад худалдаалсан гэмт хэрэг үйлдсэн 1

иргэнийг ОХУ-аас, 1 иргэнийг Испани улсаас тус тус шилжүүлэн авсан.

Монгол Улс Испанийн Хаант Улсын хооронд “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ” байгуулагдаагүй боловч мансууруулах бодисын эсрэг олон улсын гэрээ, конвенциор хүлээсэн үүргийн хүрээнд 2 талаас өндөр хүчин чармайлт гарган ажилласаны үр дүнд мансууруулах бодис бусдад зарж борлуулах гэмт хэрэг үйлдэн оргон зайлж Испани улсад орогнож байсан Монгол Улсын иргэнийг 2 талын хууль тогтоомжын хүрээнд шилжүүлэн авсан нь өндөр ач холбогдол бүхий практикийг бий болгосон байна.

Уг ажиллагаанд Олон улсын Эрүүгийн цагдаагийн байгууллага (INTERPOL), Гадаад хэргийн яам, Франц Улс дахь Монгол Улсын Элчин сайдын яам, Холбооны Бүгд Найрамдах Герман улс, Арабын Нэгдсэн Эмират Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсуудын эрх бүхий байгууллагууд өндөр хүчин чармайлт гарган ажилласаныг тэмдэглэх нь зүйтэй. Өнөөдрийн байдлаар Монгол Улсаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх, тээвэрлэх, худалдах гэмт хэрэгт гадаад улсад 44 иргэн ял эдэлж байгаа нь тухайн улсуудын хууль сахиулах байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхтэй

өрнүүлэх шаардлагатайг харуулж байна⁹⁷.

Дүгнэлт.

Мансууруулах бодисын хууль бус эргэлт тухайлбал тариалалт, тээвэрлэлт, нийлүүлэлт, түгээлт, хэрэглээнд даркнет болон интернэт цахим орчин ашиглах өөрчлөлт орж байгааг энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилго бүхий олон улсын судалгаа, шинжилгээний байгууллагууд дүгнэж байна.

Цагдаагийн байгууллагаас зохион явуулсан удаа дараагийн идэвхтэй арга хэмжээний үр дүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хомсдол бий болж, хууль бус нийлүүлэлт багассан боловч хар тамхи, мансууруулах бодисыг улсын хилээр нэвтрүүлэх арга, хэлбэр нарийсаж карго үйлчилгээ, олон улсын шуудан илгээмж, ачаа тээвэр /импортын бараа бүтээгдэхүүнд нуух/, даркнет болон интернэт цахим орчин, харилцаа холбооны далд аргыг ашиглаж байгаа нь цаашид хар тамхи, мансууруулах бодис зарж борлуулдаг этгээдүүд нь зохион байгуулалттай бүлэглэлийн шинжтэй болж энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд хүндрэл үүсч болзошгүй байна.

Олон улсын байгууллагын зөвлөмж, бусад улсын туршлагыг судлахад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэдэг хүнийг баривчлах, шийтгэхээс илүү тэднийг аль болох эрт илрүүлэх,

хэрэглээнээс татгалзуулах, эмчлэх, нийгэмшүүлэх, шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх болон иргэний нийгмийн байгууллагыг ихээр татан оролцуулснаар хэрэглэгч, донтогч нарын тоо буурч үр дүнд хүрч байгаа нь харагдаж байна.

Дэвшүүлсэн санал.

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг даркнет болон интернэт цахим орчин, харилцаа холбооны далд аргыг ашиглаж байгаа энэ үед цахим орчинд тавих хяналтыг сайжруулах бусад Улс оронтой цахим хэлбэрээр мэдээ мэдээллийг түргэн шуурхай солилцох хамтын ажиллагааг өргөжүүлэх.

2. Гэмт хэргийг индекс болон индекс бус гэмт хэрэг гэж 2 ангилан бүртгэж, улмаар гэмт хэрэгтэй тэмцэх стратеги, түүнд шаардагдах төсөв тодорхойлох. Индекс гэмт хэрэгт нь түгээмэл үйлдэгддэг хүнийг алах, бие махбодид хохирол учруулах, хулгайлах, дээрэмдэх, хүчиндэх, эд хөрөнгө устгах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэх мэт гэмт хэргийг хамааруулах. Харин индекс бус гэмт хэрэг гэдэгт түгээмэл биш боловч нийгмийн хор аюул ихтэй бусад төрлийн гэмт хэрэг хэрэг, тухайлбал хүн амын эрүүл мэнд, байгаль орны эсрэг гэмт хэрэг гэж хоёр ангилан гэмт хэрэгтэй тэмцэх стратегийг зөв

⁹⁷ ГХЯ-ны Консулын газраас ирүүлсэн мэдээлэл. (2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар)

тодорхойлж чадах болно. Энэхүү аргачлалыг хэрэгжүүлснээр түгээмэл үйлдэгддэг гэмт хэргийн гаралтыг бууруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж чадна гэж үзэж байна.

3. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэттэй тэмцэхэд зориулж хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа, техник технологи, хүний нөөцийг чадавхижуулах, тулгамдаж буй асуудлыг цогцоор шийдвэрлэхэд чиглэсэн үе шаттай арга хэмжээ авах. Нөгөөтэйгүүр, Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоол “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангахад ихээхэн анхаарах.

4. Үндэсний хөтөлбөрт энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хийсэн суурь болон хавсарга судалгаа, шинжилгээний ажлыг мэргэшсэн эрдэмтэн, судлаачдаар хийлгэх.

5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээтэй, донтолттой этгээдийг тодорхой хугацаанд бүртгэл-хяналтанд авах, эрүүл мэнд, нийгмийн халамжийн тусламж үйлчилгээг үзүүлэх “Дэмжих төв” байгуулан цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, эрүүл мэндийн байгууллага зэрэг чиг үүргийн байгууллагууд хамтран ажиллах зэрэг саналыг дэвшүүлж байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт.

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль.
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.
3. Ж.Болдбаатар. Хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн болон криминологи шинж. – УБ.2000.
4. Д.Адьяабазар. Мафи /Гэмт байгууллага/. – УБ. 1999.
5. Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь. – УБ. 1966.
6. С.Гантулга нар. Монгол Улсын эрүүгийн эрх зүй /тусгай анги/. – УБ. 2018.
7. Гадаад хэргийн яамны Консулын газраас ирүүлсэн мэдээлэл. (2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар).
8. Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын мөрдөн байцаах газар. Хар тамхитай холбоотой гэмт хэргийг шалгахад анхаарах зарим асуудал. – УБ. 2014.
9. <https://www.grandnews.mn/content/read/52415.htm>.
10. https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2300_036V4.
11. UNODC, Responses to Annual Report Questionnaire and Individual Drug Seizure Database.